

**ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН
ХҮРЭЭНИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН
НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН**

Аудитын код: САГ-2017/8/СТА-ТЕЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар харилцана уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Я.Самбууням

Утас: 261205 Цахим хаяг: sambuunyamyа@audit.gov.mn

Ахлах аудитор Л.Хонгорзул

Утас: 261205 Цахим хаяг: khongorzull@audit.gov.mn

Улаанбаатар хот

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	2
2	Аудитын тайлан.....	4
2.1	Оршил.....	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго	4
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	6
2.5	Дотоод хяналт	7
2.6	Төсвийн орлого, зардлын гүйцэтгэлийн талаарх тайлбар	7
2.7	Шилэн дансны мэдээлэл	8
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	8
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл.....	8
2.9.1	Батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулсан талаар	8
2.9.2	“Дипломат-95 цогцолбор” орон сууцны хувьчлалын талаар.....	9
2.9.3	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар	9
2.9.4	АСЕМ-ын үйл ажиллагааг зохион байгуулахтай холбоотой илэрсэн зөрчлүүдийн талаар.....	10
1.9.5	Төсвийн ерөнхийлөн захирагчийн харъяа шууд болон төвлөрүүлэн захирагчдийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн.....	12
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал	13
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	13
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	14
2.13	Өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилт	14
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:.....	14
2.15	Хязгаарлалттай санал дүгнэлт.....	14
3	Менежментийн захидал	16
3.1	Зардал	17
3.2	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар	18
3.3	АСЕМ-ыг зохион байгуулахтай холбоотой зөрчлүүдийн талаар	19
4	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	22
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	22
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	23
4.3	Аудит хийгдсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	24
4.4	Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	25
4.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	26

1 Аудитын гэрчилгээ

ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД
Ц.МӨНХ-ОРГИЛ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Гадаад харилцааны сайд нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан “Санхүүгийн тайлангийн аудитын журам”-ын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Аудитын явцад хэрэгжүүлсэн горим, сорилоор олж авсан нотлох зүйлс санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

- Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа Дипломат байгууллагын үйлчилгээ эрхлэх газар нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас албан ёсны шийдвэр гараагүй байхад Ази, Европын дээд түвшний 11 дүгээр уулзалт "АСЕМ"-ыг зохион байгуулах үйл ажиллагаанд зориулж БНХАУ-ын буцалтгүй тусламжаар ирсэн 578 иж бүрдэл зочид буудлын тавилга, эд хогшилыг 13 аж ахуйн нэгж, 21 иргэнд бэлэн мөнгөөр болон зээлээр худалдсан, 4787 ширхэг албан тасалгааны тавилга, тоног төхөөрөмж /сандал, ширээ, буйдан, хурлын танхимын иж бүрдэл/-ийг 33 төрийн байгууллагад шилжүүлсэн байна.

- Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны батлагдсан төсөв нийт дүнгээр хэтрээгүй боловч Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-д заасны дагуу зохицуулалт хийлгэхгүйгээр 13 нэр төрлийн зардлыг 1,721.7 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

Аудитаар илрүүлсэн дээрх зөрчлүүд нь Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт 1, Аудитын олон улсын стандарт 505, санхүүгийн тайлангийн “Тохиолдсон байх”, “Иж бүрэн байх”, “Хэмжилт”, “Үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Дээр дурдсан алдаа, зөрчлийн санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөллийг эс тооцвол Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОР

Д.ХҮРЭЛБААТАР

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Гадаад харилцааны сайд Ц.Мөнх-Оргил танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, төсвийн гүйцэтгэлийн тайлагнал, үйл ажиллагаандаа холбогдох хууль, дүрэм журмыг мөрдөж ажиллах зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2017 оны 4 дүгээр сарын 10-наас 2017 оны 4 дүгээр сарын 20-ны хооронд хийж, аудитын тайланг 2017 оны 4 дүгээр сарын 25-нд эцэслэн баталгаажуулж, Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Л.Хонгорзул хариуцаж хэрэгжүүлэв.

Гадаад харилцааны сайд эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Гадаад харилцааны дэд сайдын 2017 оны 08/1918 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт хуулийн хугацаанд ирүүлсэн байна.

2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Гадаад хэргийн яам *“Монгол Улсын аюулгүй байдал, үндэсний хөгжилд таатай гадаад орчныг бүрдүүлэхэд оршино”* гэсэн эрхэм зорилгын хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Хилийн чанадад байгаа иргэдийнхээ эрх ашгийг хамгаалах;
- Дэлхийн улс орнуудтай бодит харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэх;
- Бүс нутаг дахь байр сууриа бэхжүүлэх;
- Эх орныхоо нэр хүндийг өргөж, улсаа дэлхий нийтэд таниулах;
- Дипломат алба, үйл ажиллагааг шинэчилэх.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхдээ “Монгол Улсын гадаад харилцааг үндэсний аюулгүй байдлын болон гадаад бодлогын үзэл баримтлалд тодорхойлсон зарчим, чиглэлээр улс орны болон дэлхий дахины улс төр, эдийн засгийн шинэ нөхцөл байдалтай уялдуулан тууштай хэрэгжүүлж, үндэсний язгуур эрх ашиг, тогтвортой хөгжлийн зорилгод нийцсэн бие даасан, нээлттэй, олон тулгуурт гадаад бодлогыг идэвхтэй явуулах, гадаад бодлогын залгамж чанар, нэгдмэл байдлыг эрхэмлэж, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, олон улсын хамтын нийгэмлэгт эзлэх байр суурийг бэхжүүлэх, гадаад эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх үйл ажиллагааг тууштай явуулах зорилтуудыг удирдлага болгоно” гэж үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.8-д *“Засгийн газрын гишүүн холбогдох төрийн захиргааны төв байгууллагын болон түүнд хууль тогтоомжоор харъяалуулсан бусад байгууллагын төсвийн”* гэж заасны дагуу Гадаад харилцааны сайд төсвийн ерөнхийлөн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Засгийн газрын 2016 оны “Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг батлах тухай” 3 дугаар тогтоолоор Гадаад харилцааны яамны аппаратын бүтэц, орон тооны хязгаарыг баталсны дагуу 2016 оны жилийн эцсийн байдлаар улс төрийн албан тушаалтан -3, төрийн тусгай албан хаагч /дипломат ажилтан/-97, төрийн захиргааны албан хаагч-21, төрийн үйлчилгээний албан хаагч-14, гэрээт ажилтан 7, нийт 142 хүн ажиллаж байна.

Хилийн чанадад Монгол Улсын 46 Дипломат төлөөлөгчийн газар /ДТГ/ үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд эдгээрт нийт 319 ажилтан (дипломат-236, техник ажилтан-83) ажиллаж байна.

Гадаад харилцааны яамны үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлснээс гадна Гадаад харилцааны сайдын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

Дотоод хяналтын талаарх гол асуудал, дүгнэлтийг энэ тайлангийн 2.5-д үзүүлэв.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 4 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 10 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлоготой танилцахад нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, журам заавартай нийцэж байгаа боловч дараах асуудлыг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт дэлгэрэнгүй тусгах нь зүйтэй. Үүнд:

- Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан журам, маягт аргачлалыг тусгах;
- Төсвийн орлого, зарлагын эдийн засгийн ангилалыг шинэчилэх;
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас шинээр гарсан бодлого шийдвэртэй холбоотой асуудал.

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл “бага” буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайлан бэлтгэхэд төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэдэг “Э-тайлан” програм хангамж ашигласан байна.

Гадаад харилцааны яамны санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулан Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг бэлтгэсэн байна.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Гадаад харилцааны сайдын төсвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт эхний хагас жилд “хангалтгүй” ажилласан байна гэж үзлээ.

Гадаад харилцааны яамны дотоод аудитын алба нь 2016 оны эхний хагас жилд Төрийн захиргааны удирдлагын газарт харъяалагдаж дээд газрын шийдвэр, эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт, Засгийн газрын хуралдаанаар 2016 онд хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөний биелэлт гаргаж ЗГХЭГ-т хүргүүлэх, ТЕЗ-ийн төсвийн шууд захирагчтай байгуулсан 2015 оны үр дүнгийн гэрээг дүгнэх, 2016 оны үр дүнгийн гэрээг байгуулах зэрэг ажлуудыг гүйцэтгэхээр ажлын төлөвлөгөө батлуулан ажилласан боловч дотоод аудитын чиглэлээр ажил гүйцэтгээгүй байна.

Засгийн газрын 2016 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн 3 дугаар тогтоолын дагуу “Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар”-ыг 5 ажилтны орон тоотойгоор /газрын захирал, дэд захирал, дипломат ажилтан, мэргэжилтэн, санхүүгийн аудитор/ байгуулсан боловч ажил гүйцэтгэх ажилтны тоо хангалтгүй байгаа нь санхүүгийн дотоод хяналтыг сулруулах эрсдэлийг дагуулж байна.

Шинээр зохион байгуулагдсан “Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар” нь ТНБД-ын 2016 оны А/69 дүгээр тогтоолын дагуу Консулын газраас “Дипломат, албан паспорт” олгосон үйл ажиллагаа, Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хяналт, шалгалт хийж дүнг яамны удирдлагад танилцуулж, нийт 7 төрлийн зөвлөмж өгсөн байна.

Аудитын явцад төлөвлөсөн горим сорилын дагуу дотоод аудитын албаны үйл ажиллагаатай танилцаж, тэдний үүрэг чиглэл, үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнгийн талаарх мэдээллийг ажлын баримтанд хавсаргалаа.

2.6 Төсвийн орлого, зардлын гүйцэтгэлийн талаарх тайлбар

Гадаад харилцааны яамны төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны урсгал зардалд зарцуулахаар 74,338.4 сая төгрөгийн төсөв батлуулснаас 70,592.8 сая төгрөг зарцуулсан байна.

Батлагдсан төсвийн гүйцэтгэлийн талаарх мэдээллийг орлого, зардлын ангилал тус бүрээр аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн дэлгэрэнгүйд тусгаж тайлангийн 4.5-д харуулав.

Батлагдсан төсвийн гүйцэтгэлийн тайлангаас үзэхэд багаж техник хэрэгсэл худалдан авах зардлыг 226.8 сая төгрөгөөр буюу батлагдсан төсвөөс 10 дахин, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 704.9 сая төгрөгөөр буюу батлагдсан төсвөөс 5 дахин хэтрүүлэн зарцуулсан нь анхаарал татахуйц их хэмжээний хэлбэлзэлтэй байна.

Монгол Улсад 2016 онд Ази, Европын дээд түвшний 11 дүгээр уулзалт “АСЕМ”-ыг зохион байгуулах үйл ажиллагаанд зориулж Гадаад харилцааны сайдын төсвийн

багцад нийт 21,104.9 сая төгрөг батлагдснаас гүйцэтгэлээр 19,268.7 сая төгрөг зарцуулсан байна.

2.7 Шилэн дансны мэдээлэл

Гадаад харилцааны сайд төсвийн ерөнхийлөн захирагчийн шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хангах зорилтын хүрээнд *shilendans.gov.mn* цахим хуудасны төсөв/гүйцэтгэл, хөрөнгө оруулалт, бусад гэсэн цонхнуудад дараах мэдээллийг байршуулж байх үүрэгтэй байна. Үүнд:

А. Төсөв/гүйцэтгэл цэсэнд:

1. Дараа жилийн төсвийн төсөл (Бүтэн жилээр)
2. Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт (Бүтэн жилээр, Хагас жилээр, Улирал бүр, Сар бүр)
3. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт (Тухай бүр)
4. Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр)
5. Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр)
6. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (Тухай бүр)
7. Санхүүгийн тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр)
8. Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт (Бүтэн жилээр)
9. Байгууллагын батлагдсан төсөв (Бүтэн жилээр)

Дээрх мэдээллийг нийтэд ил тод мэдээлсэн талаар шалгаж үзэхэд илэрсэн зөрчлийн талаар тайлангийн 2.9.5 хэсэгт тусгасан болно.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын чиглэлийн 10 эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 10 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

2.9.1 Батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулсан талаар

- Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны батлагдсан төсөв нийт дүнгээр хэтрээгүй боловч үндсэн цалин 145.5 сая, НДШ 4.5 сая, байрны түрээс 442.9 сая, бичиг хэрэг 60.8 сая, тээвэр шатахуун 200.5 сая, шуудан холбоо 198.3 сая, БҮТЭЗ 200.2 сая, эд хогшил худалдан авах зардал 88.8 сая, зочин төлөөлөгч хүлээн авах зардал 42.3 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 194.2 сая, газрын төлбөр 15.4 сая, банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж 21.2 сая, хичээл үйлдвэрлэлийн зардал 89.5 сая, ном хэвлэлийн зардал 17.6 сая, нийт 1,721.7 сая төгрөгөөр батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6

дугаар зүйлийн 6.4.1-д *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах"*, 14 дүгээр зүйлийн 14.2.3-т Төсвийн ерөнхийлөн захирагч *"өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах"*, 41 дүгээр зүйлийн 41.2.2-т *"батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах"* гэсэн заалтуудтай;

- Хилийн чанадад байгаа Монгол улсын иргэдэд туслах сангаас 2016 онд Гадаад харилцааны сайдын 2015 оны А/95, 2016 оны А/58 дугаар тушаалуудаар ГХЯ-ны 2 ажилтныг гадаадад эмчилгээ хийлгэхэд дэмжлэг болгож 7.4 сая төгрөг олгосон нь Засгийн Газрын 2008 оны 110 дугаар тогтоолоор батлагдсан *"Хилийн чанадад байгаа Монгол улсын иргэдэд туслах сангийн дүрэм"*-ийн 4.3-т заасан сангийн хөрөнгөөс тусламж олгох, 6.2-т *"Сангийн хөрөнгийг батлагдсан төсвөөс хэтрүүлэх, өөр зориулалтаар ашиглах, зарцуулахыг хориглоно"* гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Төсвийн тухай хууль, УСНББОУС, УИХ-ын 2016 оны 47 дугаар тогтоол, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан *"Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"* зэргийг хэрэгжүүлж ажиллах, үргүй зардлыг бууруулах талаар зөвлөмж өгөх

2.9.2 “Дипломат-95 цогцолбор” орон сууцны хувьчлалын талаар

Гадаад харилцааны сайдын 2016 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр 02/142 дугаар албан бичгээр Сангийн сайдад Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 6 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 5,336.9 сая төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий *"Дипломат 95 цогцолбор"* орон сууцыг үнэтэй хувьчлах тухай саналыг хүргүүлсэн байна.

Гэтэл Засгийн газрын 2016 оны 223 дугаар тогтоолоор 1998 оны 148 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан *"Хувьчлалд үл хамаарах орон сууцны жагсаалт"*-ын 14-т *"Монгол улс дахь БНЧУ_ХБНЮУ-ын ЭСЯ, АНУ-ын Энх Тайвны Корпусын эзэмшлийн Дипломат-95 айлын орон сууц"* гэсэн заалтыг хүчингүй болгон 2016 оны 315 дугаар тогтоолоор ГХЯ-ны албан хаагчдад үнэ төлбөргүй хувьчилахаар шийдвэрлэсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д *"Улсын Их Хурал бүх ард түмнийг төлөөлөн төрийн өмнөөс өмчлөгч байх"*, 8.5-д *"төрийн өмчийг хувьчлах үндсэн чиглэл, хувьчилж үл болох эд хөрөнгийн жагсаалтыг батлах, түүнд өөрчлөлт оруулах"*, Монгол Улсын Их Хурлын 1999 оны 64 дүгээр тогтоолоор батлагдсан *"Төрийн өмчөөс хувьчилж үл болох эд хөрөнгийн жагсаалт"*-ын 1.4 дэх заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

- Монгол Улсын Засгийн газраас гаргасан шийдвэр нь холбогдох хууль, УИХ-ын тогтоолыг зөрчсөн байх тул шийдвэрээ дахин хянаж үзэх талаар Монгол Улсын Ерөнхий сайдад хүсэлт гарган холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх талаар албан шаардлага хүргүүлэх

2.9.3 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн ерөнхийлөн захирагчийн шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хангах зорилтын хүрээнд:

- ГХЯ нь (shilendans.gov.mn) вэб хуудсанд шилэн дансны мэдээллийг байршуулж ирсэн боловч 2016 оны 12 дугаар сард 75.6 сая төгрөгийн зарлагын мэдээллийг байршуулаагүй байгаа нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг" гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

- Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар нь Шилэн дансны төсөв гүйцэтгэл цэсэнд 9 мэдээлэл байршуулахаас 2 мэдээллийг огт байршуулаагүй, зарлагын гүйлгээнд холбогдох шийдвэрийн хуулбарыг бүрэн хавсаргаагүй;

- Юнескогийн Монголын үндэсний комисс нь Шилэн дансны төсөв гүйцэтгэл цэсэнд 9 мэдээлэл байршуулахаас 6, бусад цэсэнд 6 мэдээлэл байршуулахаас 1 мэдээллийг огт байршуулаагүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн холбогдох заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг бүрэн байршуулах, уг хуулийг мөрдөж ажиллах талаар завлөмж өгөх

2.9.4 АСЕМ-ын үйл ажиллагааг зохион байгуулахтай холбоотой илэрсэн зөрчлүүдийн талаар

- ГХЯ-ны Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар нь Ази, Европын дээд түвшний 11 дүгээр уулзалт "АСЕМ"-ыг зохион байгуулах үйл ажиллагаанд зориулж БНХАУ-ын буцалтгүй тусламжаар ирсэн 578 иж бүрдэл зочид буудлын тавилга, тоног төхөөрөмж хүлээн авсан бөгөөд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар /ТӨБЗГ/-аас албан ёсны шийдвэр ирээгүй байхад Үндэсний зөвлөлийн 21 дүгээр хуралдааны шийдвэрийн дагуу зочид буудлын тавилгуудыг АСЕМ-ын түнш зочид буудлууд болон хувь хүн, ААН-д 1,271.5 сая төгрөгөөр үнэлж худалдсан боловч 814.0 сая төгрөгийн төлбөрийг аваагүй, төвлөрүүлсэн 457.5 сая төгрөгийн орлогыг улсын төсөвт шилжүүлээгүй, 61 иж бүрдэл буюу 133.8 сая төгрөгийн тавилгыг төрийн байгууллагуудад үнэ төлбөргүй шилжүүлсэн зэрэг нь ТБОНӨТ хуулийн 30 дугаар зүйлийн 30.2-т "... төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр шилжүүлж болно" гэсэн заалт, Үндэсний зөвлөлийн 21 дүгээр хуралдаанаас гарсан "БНХАУ-ын буцалтгүй тусламжаар ирэх тавилга, тоног төхөөрөмжийг зочид буудлуудад үнийн дүнгээс 50 хувиар багасган, 30 хувийг бэлнээр төлж, үлдэгдэл 20 хувийг 2016 онд багтаан төлөх зарчмаар ажиллах" гэсэн шийдвэртэй тус тус нийцэхгүй байна.

- ДБҮЭГ-ын захирал нь 2016 оны 07 дугаар сарын 19-ний өдөр "НЬЮ ТЕРРАВОКС" ХХК-тай БНХАУ-ын буцалтгүй тусламжаар ирсэн 6955 нэгж орчуулгын тоног төхөөрөмжийг түрээсүүлэхээр 3 жилийн хугацаатай "Тоног төхөөрөмж түрээслэх, түрээслүүлэх гэрээ" -г байгуулсан байна. Тус гэрээнд түрээслэгч тал нь гэрээний хугацаанд түрээслүүлэгч талаас зохион байгуулах арга хэмжээг өөрийн зардлаар үнэ төлбөргүйгээр хариуцан ажиллаж, гэрээний хугацаа дууссанаар тоног төхөөрөмж түрээслэгч талд үнэ төлбөргүйгээр шилжихээр түрээсийн төлбөрийг тусгасан нь ТБОНӨТ хуулийн 30 дугаар зүйлийн 30.2-т "... төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр шилжүүлж болно" гэсэн заалттай нийцэхгүй байна.

- БНХАУ-ын буцалтгүй тусламжаар ирсэн 5572 нэгж ширхэг албан тасалгааны тавилга, тоног төхөөрөмж /сандал, ширээ, буйдан, хурлын танхимын иж бүрдэл/-өөс 4787 ширхэгийг 33 төрийн байгууллагуудад тэдний хүсэлт болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын албан бус шийдвэр цохолтоор үнэ төлбөргүй шилжүүлсэн, иргэд, аж ахуйн нэгжүүдэд 785 ш тавилгыг 103.0 сая төгрөгөөр худалдсанаас 97.3 сая төгрөгийн төлбөрийг аваагүй байгаа зэрэг нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2-т *"... төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр шилжүүлж болно"* гэсэн заалттай нийцэхгүй байна.

- "АСЕМ"-ын үйл ажиллагаанд зарцуулахаар батлагдсан төсвөөс 70.4 сая төгрөгийг ГХЯ-ны сайд, ажилтнуудын тус үйл ажиллагааг зохион байгуулахтай холбогдолгүй гадаад томилолтын арга хэмжээнд, 117.9 сая төгрөгийг ГХЯ-ны байр болон гаднах талбайн засварт зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т *"батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих"* гэсэн заалттай нийцэхгүй байна.

- Ази, Европын дээд түвшний 11 дүгээр уулзалт "АСЕМ"-ыг зохион байгуулах үйл ажиллагаанд зориулж худалдан авсан 6.1 сая төгрөгийн хөрөнгө, 1,050.8 сая төгрөгийн бараа материалыг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардлаар тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д *"Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг мөрдөнө"*, УСНББОУС 12 - Бараа материал гэсэн стандарт, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан *"Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"*-ын 4.15-д *"Бараа материал гэдэг нь байгууллагын хэвийн үйл ажиллагааны явцад хэрэглэгдэх материал буюу хангамжийн зүйлс ..."* гэж заасантай нийцэхгүй байна.

- Ази, Европын дээд түвшний 11 дүгээр уулзалтанд оролцсон гадаадын зочин төлөөлөгч нарт 1 хүнд 0.1 - 4.9 сая төгрөгийн бэлэг, дурсгалын зүйл гардуулсан нь ЗГ-ын 1999 оны 198 дугаар тогтоолоор батлагдсан *"Бэлэг дурсгалын зүйл гардуулах, хүлээн авах, тайлагнах, зарцуулах журам"*-ын 2.3-т *"Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайд албан ёсны айлчлалаас бусад үед гадаад, дотоодын зочин, төлөөлөгчдөд бэлэг, дурсгалын зүйл гардуулах, илгээхэд Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 100.0 мянга, УИХ-ын дарга, Ерөнхий сайдаас 80.0 мянга"*, 2.4-т *"Монгол Улсын Гадаад харилцааны сайдаас гадаадын зочин төлөөлөгчдөд нэг хүнд 65.0 мянган төгрөгөөс ... тус тус илүүгүй үнэтэй зүйл нэг хүнд ногдохоор ..."* гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

- Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2014 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 63/37 дугаар зөвлөмж, 2016 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн 4/77 тоот албан бичгээр ГХЯ-д ирүүлсэн чиглэлийн дагуу "АСЕМ"-ын үйл ажиллагаанд зарцуулахаар батлагдсан төсвөөс 12.429.6 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээний ханган нийлүүлэгч, гүйцэтгэгчтэй шууд худалдан авах гэрээ байгуулан ажилласан байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн газар "Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай" хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2-т *"Зөвлөлийн шийдвэрийг үндэслэн түүний хүрээнд төрийн дээд, төв байгууллага, албан тушаалтан өөрийн чиг үүрэг, бүрэн эрхийнхээ дагуу холбогдох шийдвэр боловсруулан гаргаж зохих журмаар хэрэгжүүлнэ"* гэсний дагуу Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийг хэрэгжүүлэх шийдвэр гаргаагүй, Үндэсний аюулгүй байдлын

зөвлөлөөс ГХЯ-д ирүүлсэн чиглэл нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 3.4 дэх заалтыг үндэслэсэн боловч Монгол Улсад Ази, Европын дээд түвшний 11 дүгээр уулзалтыг зохион байгуулахтай холбоотой худалдан авах ажиллагааг төрийн нууцад хамааруулсан шийдвэр ГХЯ-нд байхгүй, бүх бичиг баримтад нууцын тэмдэг дарагдаагүй тул дээрх худалдан авах ажиллагаа нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.2-т *"... босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ"*, Төсвийн тухай хуулийн 6.4.1-д *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"* гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

- Ази, Европын дээд түвшний 11 дүгээр уулзалт АСЕМ-ыг Монгол Улсад зохион байгуулах ажлыг идэвхитэй сайн зохион байгуулсан ажлын хэсэг, ажилтнуудад зориулсан хүлээн авалтын зардалд 393.0 сая төгрөг, алтан мөнгөн талархалын бичигний үнэнд 16.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"* гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

- "АСЕМ"-ын хүрээнд бэлтгэгдсэн хөрөнгүүдийг холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэрийн дагуу данс бүртгэлд тусгах, шилжүүлэх, худалдан борлуулах үйл ажиллагааг зохион байгуулах, өр авлагыг барагдуулах талаар албан шаардлага өгөх;

- Зочид буудлын иж бүрдэл тавилгуудыг худалдан борлуулсны орлого 457.5 сая төгрөгийг улсын төсөвт татан төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоох;

- Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаанд ТБОНӨХБАҮХАТХ хууль болон бусад холбогдох журмыг мөрдөж ажиллах, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулахгүй байх талаар зөвлөмж өгөх.

2.9.5. Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа шууд болон төвлөрүүлэн захирагчдын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэлээс:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн шууд захирагч 2, төвлөрүүлэн захирагч 1, ТӨҮГ 1, Засгийн газрын тусгай сан 2, төсөл хөтөлбөр 1, нийт 7 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн бөгөөд эдгээрийн 57.1 хувь буюу 4 нь аудитад хамрагдаж, бүгд зөрчилгүй дүгнэлт авсан байна.

Гадаадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах санг Үндэсний аудитын газрын түүвэр аудитад хамруулж, Олон улсын хамтын ажиллагааны санд 2016 онд төсөв батлагдаагүй тул өмнөх онд татан төвлөрүүлж, 2016 онд буцааж олгосон 14.2 сая төгрөгийн зарцуулалтыг түүвэрт хамруулж Гадаад харилцааны сайдын төсвийн багцын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийх аудитыг гүйцэтгэлээ.

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчдын 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 12,264.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 3,785.9 сая төгрөгийн материаллаг алдааг аудитын явцад залруулж, 5,281.7 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, цаашид давтан гаргахгүй байх 3 албан шаардлага, 3,196.8 сая төгрөгийн зөрчилд 8 зөвлөмж хүргүүлэв.

Аудитаар илэрсэн бүх асуудлыг төсвийн ерөнхийлөн захирагч болон яамны удирдлага, дотоод аудитын нэгж авч үзэж, судлан шийдвэрлэх шаардлагатай бөгөөд төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах асуудлыг төсвийн ерөнхийлөн захирагчийн анхааралд онцгойлон хандуулж байна. Үүнд:

1. Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний Дипломат төлөөлөгчийн газрын харъяа Казакстан Улсын Дипломат төлөөлөгчийн газрын үндсэн хөрөнгийн ангилалын барилга, байгууламж дансанд бүртгэгдсэн 600.5 мянган ам.долларын үнэ бүхий барилга нь биетээр оршин байхгүй байгаа нь санхүүгийн тайлангийн “Оршин байх”, “Толилуулга ба тодруулга”, “Үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдэл, УСНББОУС 17-д заасан Үндсэн хөрөнгө, Үндсэн хөрөнгийн хүлээн зөвөөрөлт гэсэн тодорхойлолтуудыг хангаж чадахгүй байна.

2. ГХЯ-ны “Ёслол хүндэтгэлийн өргөө”-ний барилга угсралтын ажлыг гүйцэтгэх нээлттэй тендерт “ХӨ МО ТЭ” ХХК шалгарч, 2014 оны 10 дугаар сарын 01-ний дотор ашиглалтад оруулах нөхцөлтэй гэрээ байгуулан, 2013 оноос хойш нийт 4.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон боловч одоог хүртэл барилга ашиглалтад ороогүй, санхүүгийн тайлангийн дуусаагүй барилга дансанд бүртгэлтэй явж байгаа нь Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 73 дугаар тогтоолоор баталсан “Барилга захиалагчийн дүрэм”-ийн 3.2.7-д *“гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч болон зөвлөх үйлчилгээ үзүүлэгчтэй байгуулсан ажил гүйцэтгэх гэрээг тогтоосон хугацаанд дүгнэж, хариуцлага тооцож ажиллах”*, Гадаад харилцааны яам, “ХӨМОТЭ” ХХК-ийн хооронд 2013 оны 7 дугаар сарын 17-ны өдөр байгуулсан “Гадаад харилцааны яамны Ёслол хүндэтгэлийн өргөөний барилгын талбай чөлөөлөх, барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээ”-ний 5-д *“Гүйцэтгэгч нь ... 2014 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ашиглалтад оруулах”* гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Аудитын явцад илэрсэн алдааг төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагч нар хүлээн зөвшөөрсөн байна.

2.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн тайланг нэгтгэн гаргаж байгаа Төв төрийн сангийн “Э-тайлан” програм хангамж хэвийн ажиллаагүй, програмаас хэвлэгдэж буй санхүүгийн байдлын тайланд Засгийн газрын хувь оролцооны дүн дутуу татагдсан, төсвийн хэлбэлзлийн тайлан эцэслэгдээгүй зэрэг нь сайдын эрхэлсэн асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайланг Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгүүлэхэд зарим тоон мэдээлэл өөрчлөгдөх эрсдэл үүсгэх магадлалтай байна.

2.11 Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

- Аудитын явцад гүйцэтгэсэн горим сорил, зарим аудитын чиглэлд өгсөн эрсдэлийн үнэлгээ зэргээс үзэхэд ДТГ-ын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн барилга байгууламж дансанд бүртгэгдсэн 1,288.4 сая төгрөг /600.5 мянган ам.долларын/-ийн дансны үнэ бүхий Казакстан Улсын ДТГ-ын барилга биетээр оршин байхгүй байгаа тул УСНББОУС 17-д заасан үндсэн хөрөнгө гэсэн тодорхойлолтыг хангаж чадахгүй байна. Энэ хөрөнгийг аудитын явцад баталгаажуулах боломжгүй байгаа тул дараагийн аудитаар авч үзэх, мөн үндсэн хөрөнгө болон бараа материал дансанд хөрөнгө бодитой оршин байгаа эсэхэд горим хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

- "АСЕМ"-ыг зохион байгуулах үйл ажиллагаанд зориулж БНХАУ-ын буцалтгүй тусламжаар ирсэн тавилга, тоног төхөөрөмжийн үнэлгээ болон төрийн байгууллагуудад үнэ төлбөргүй шилжүүлэх, иргэд, аж ахуйн нэгжид зээлээр худалдах талаар Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас ямар нэгэн шийдвэр гараагүй байгаа нь өмч хөрөнгийн бүрэн бүтэн байдал алдагдах, улсын төсөвт төвлөрөх орлого хугацаандаа төвлөрөхгүй байх эрсдлийг дагуулж байна.

Иймд энэ асуудлыг эрсдлийн аудитаар нарийвчлан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

2.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитаар нийт 23,229.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 3.785.1 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 457.5 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 5,281.7 сая төгрөгийн 10 зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлж, 13,703.9 сая төгрөгийн зөрчилд цаашид холбогдох хууль тогтоомжийг мөрдөж, дээрх алдаа зөрчлийг давтан гаргахгүй ажиллах талаар зөвлөмж өгсөн.

2.13 Өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилт

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд Үндэсний аудитын газраас хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 4 зөвлөмжөөс 3-ыг биелүүлж, Монгол Улсаас гадаадад суугаа ДТГ-уудын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа "Макс" санхүүгийн програмыг шинэчлэх талаар өгсөн 1 зөвлөмж хэрэгжээгүй байна. Зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг Гадаад харилцааны яамны 2017 оны 14/2108 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Дэлгэрэнгүй мэдээллийг ажлын баримтад хавсаргасан болно.

2.14 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгов.

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 106,401.1 мянган төгрөг бөгөөд түвшинг түүний 2 хувиар тооцож 2,128.0 сая төгрөгөөр материаллаг байдлыг тогтоосон бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд тооцсон суурь болон түвшинд өөрчлөлт ороогүй болно.

2.15 Хязгаарлалттай санал дүгнэлт

Бид Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого бүртгэл хөтлөлт, програм хангамж дотоод хяналтын систем тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний харъяа Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас албан ёсны шийдвэр гараагүй байхад Ази, Европын дээд түвшний 11 дүгээр уулзалт "АСЕМ"-ыг зохион байгуулах үйл ажиллагаанд зориулж БНХАУ-ын буцалтгүй тусламжаар ирсэн 578 иж бүрдэл зочид буудлын тавилга, тоног төхөөрөмжийг 13 аж ахуйн нэгж, 21 иргэнд бэлэн мөнгөөр болон зээлээр худалдсан, 4787 ширхэг албан тасалгааны тавилга, тоног төхөөрөмж /сандал, ширээ, буйдан, хурлын танхимын иж бүрдэл/-ийг 33 төрийн байгууллагад шилжүүлсэн зэрэг нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2-т "... төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр шилжүүлж болно" гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Оршин байх", "Үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны батлагдсан төсөв нийт дүнгээр хэтрээгүй боловч Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам"-д заасны дагуу зохицуулалт хийлгэхгүйгээр 13 нэр төрлийн зардлыг 1,721.7 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т Төсвийн ерөнхийлөн захирагч "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Тохиолдсон байх", "Иж бүрэн байх", "Хэмжилт", "Үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Дээрх алдаа зөрчлийг эс тооцвол Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ОРЛОГЧИЙН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Б.БАТТУЯА

САГ-ЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР:

Я.САМБУУНЯМ

БЭЛТГЭСЭН: АХЛАХ АУДИТОР

Л.ХОНГОРЗУЛ

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнууд болон Дотоод аудитын албаны холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.

3.1 Зардал

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны батлагдсан төсөв нийт дүнгээр хэтрээгүй боловч Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам"-д заасны дагуу зохицуулалт хийлгэхгүйгээр үндсэн цалин 145.5 сая, НДШ 4.5 сая, байрны түрээс 442.9 сая, бичиг хэрэг 60.8 сая, тээвэр шатахуун 200.5 сая, шуудан холбоо 198.3 сая, БҮТЭЗ 200.2 сая, эд хогшил худалдан авах зардал 88.8 сая, зочин төлөөлөгч хүлээн авах зардал 42.3 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 194.2 сая, газрын төлбөр 15.4 сая, банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж 21.2 сая, хичээл үйлдвэрлэлийн зардал 89.5 сая, ном хэвлэлийн зардал 17.6 сая, нийт 13 нэр төрлийн зардлыг 1,721.6 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах"*, 14 дүгээр зүйлийн 14.2.3-т ТЕЗ *"өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах"*, 41 дүгээр зүйлийн 41.2.2-т *"батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах"* гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар", УИХ-ын 2016 оны 47 дугаар тогтоол, Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалыг хэрэгжүүлж ажиллах, үргүй зардлыг бууруулах

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2017 оны 12 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт албан ёсоор ирүүлэх

Эрсдэлүүд

Дараах батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна. Үүнд:

Үнэн зөв байдал - Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх

Төсвийн захирагчийн хариу

2017 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр Төсвийн ерөнхийлөн захирагчид аудитаар илэрсэн алдаа зөрчлийг танилцуулахаар хүргүүлсэн боловч хариуг ирүүлээгүй байна.

3.2 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн ерөнхийлөн захирагчийн шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хангах зорилтын хүрээнд:

- ГХЯ нь “shilendans.gov.mn” вэб хуудсанд шилэн дансны мэдээллийг байршуулж ирсэн боловч 2016 оны 12 дугаар сард 75.6 сая төгрөгийн зарлагын мэдээллийг байршуулаагүй, ДБҮЭГ нь Шилэн дансны төсөв гүйцэтгэл цэсэнд 9 мэдээлэл байршуулахаас 2 мэдээллийг огт байршуулаагүй, зарлагын гүйлгээнд холбогдох шийдвэрийн хуулбарыг бүрэн хавсаргаагүй,

- Юнескогийн Монголын үндэсний комисс нь Шилэн дансны төсөв гүйцэтгэл цэсэнд 9 мэдээлэл байршуулахаас 6, бусад цэсэнд 6 мэдээлэл байршуулахаас 1 мэдээлэлийг огт байршуулаагүй байна.

Энэ нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараахь мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг" гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг бүрэн байршуулж, хуулийг хэрэгжүүлж ажиллах

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2017 оны 12 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт албан ёсоор ирүүлэх

Эрсдэлүүд

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байх

Төсвийн захирагчийн хариу

2017 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр Төсвийн ерөнхийлөн захирагчид аудитаар илэрсэн алдаа зөрчлийг танилцуулахаар хүргүүлсэн боловч хариуг ирүүлээгүй байна.

3.3 АСЕМ-ыг зохион байгуулахтай холбоотой зөрчлүүдийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №3

ҮАГ-ын ажиглалт

1. Монгол Улсад "АСЕМ"-ыг зохион байгуулах үйл ажиллагаанд зориулж худалдан авсан 6.1 сая төгрөгийн хөрөнгө, 1,050.8 сая төгрөгийн бараа материалыг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардлаар тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д *"Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг мөрдөнө"*, УСНББОУС 12 - Бараа материал гэсэн стандарт, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан *"Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"*-ын 4.15-д *"Бараа материал гэдэг нь байгууллагын хэвийн үйл ажиллагааны явцад хэрэглэгдэх материал буюу хангамжийн зүйлс ..."* гэж заасантай нийцэхгүй байна.

2. Ази, Европын дээд түвшний 11 дүгээр уулзалтанд оролцсон гадаадын зочин төлөөлөгч нарт 1 хүнд 0.1 - 4.9 сая төгрөгийн бэлэг, дурсгалын зүйл гардуулсан байна.

Энэ нь ЗГ-ын 1999 оны 198 дугаар тогтоолоор батлагдсан *"Бэлэг дурсгалын зүйл гардуулах, хүлээн авах, тайлагнах, зарцуулах журам"*-ын 2.3-т *"Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайд албан ёсны айлчлалаас бусад үед гадаад, дотоодын зочин, төлөөлөгчдөд бэлэг, дурсгалын зүйл гардуулах, илгээхэд Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 100.0 мянга, УИХ-ын дарга, Ерөнхий сайдаас 80.0 мянга"*, 2.4-т *"Монгол Улсын Гадаад харилцааны сайдаас гадаадын зочин төлөөлөгчдөд нэг хүнд 65.0 мянган төгрөгөөс ... тус тус илүүгүй үнэтэй зүйл нэг хүнд ногдохоор ..."* гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

3. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2014 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 63/37 дугаар зөвлөмж, 2016 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн 4/77 тоот албан

ҮАГ-ын зөвлөмж

Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын дагуу бараа материалын дансаар дамжуулан зарлагаар бүртгэх, зөрчлийг давтан гаргахгүй байх, бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагаанд ТБОНӨХБАҮХАТХ болон холбогдох журмыг мөрдөж ажиллах

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2017 оны 12 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт албан ёсоор ирүүлэх

бичгээр ГХЯ-д ирүүлсэн чиглэлийн дагуу "АСЕМ"-ын үйл ажиллагаанд зарцуулахаар батлагдсан төсвөөс 12.429.6 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгчтэй шууд гэрээ байгуулан ажилласан байна.

Монгол Улсын Засгийн газар "Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай" хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2-т *"Зөвлөлийн шийдвэрийг үндэслэн түүний хүрээнд төрийн дээд, төв байгууллага, албан тушаалтан өөрийн чиг үүрэг, бүрэн эрхийнхээ дагуу холбогдох шийдвэр боловсруулан гаргаж зохих журмаар хэрэгжүүлнэ"* гэсний дагуу МУҮАБЗ-ийн зөвлөмжийг хэрэгжүүлэх шийдвэр гаргаагүй, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс ГХЯ-д ирүүлсэн чиглэл нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 3.4 дэх заалтыг үндэслэсэн боловч АСЕМ-ыг зохион байгуулахтай холбоотой худалдан авах ажиллагааг төрийн нууцад хамааруулсан шийдвэр ГХЯ-нд байхгүй, бүх бичиг баримтад нууцын тэмдэг дарагдаагүй тул дээрх худалдан авах ажиллагаа нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.2-т *"... босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ"*, Төсвийн тухай хуулийн 6.4.1-д *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"* гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

4. "АСЕМ"-ын үйл ажиллагаанд зарцуулахаар батлагдсан төсвөөс 70.4 сая төгрөгийг ГХЯ-ны сайд, ажилтнуудын тус үйл ажиллагааг зохион байгуулахтай холбогдолгүй гадаад томилолтын зардалд, 117.9 сая төгрөгийг ГХЯ-ны байр болон гаднах талбайн засварын зардалд зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т *"батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих"* гэж заасантай нийцэхгүй байна.

5. Ази, Европын дээд түвшний 11 дүгээр уулзалт АСЕМ-ыг Монгол Улсад зохион байгуулах ажлыг идэвхитэй сайн зохион байгуулсан ажлын хэсэг, ажилтнуудыг хүлээн

авалтын зардалд 393.0 сая, алтан, мөнгөн талархалын бичигний үнэнд 16.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"* гэсэн заалттай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлангийн бодит байдлын тухай мэдэгдэлтэй зөрчилдөж байгаа бөгөөд дараах батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна. Үүнд:

Үнэн зөв байдал - Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх

Төсвийн захирагчийн хариу

2017 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр Төсвийн ерөнхийлөн захирагчид аудитаар илэрсэн алдаа зөрчлийг танилцуулахаар хүргүүлсэн боловч хариуг ирүүлээгүй байна.

4 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

4.1 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг /			
Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2015 оны 12-р сарын 31	2016 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		16,294,436.6	17,024,510.2
МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	8,861,056.3	10,312,384.6
АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	4,742,177.1	3,959,811.5
УРЬДЧИЛГАА	7а, 7б	112,730.7	97,335.5
БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	2,578,472.5	2,654,978.6
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		106,712,213.8	103,709,707.2
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	106,712,213.8	103,709,707.2
Газар		231,197.8	231,197.8
Биет хөрөнгө		106,276,505.1	103,269,351.9
Биет бус хөрөнгө	13	204,510.9	209,157.5
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		123,006,650.4	120,734,217.4
НИЙТ ӨР ТӨЛБӨР		2,298,603.8	1,201,134.4
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	2,298,603.8	1,201,134.4
Өглөг	17а, 17б	2,298,603.8	1,201,134.4
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		120,708,046.7	119,533,083.0
Засгийн газрын хувь оролцоо		120,708,046.7	119,533,083.0
Хуримтлагдсан үр дүн		-10,754,924.5	-16,911,420.6
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		5,086,633.2	5,086,224.7
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		10,873,203.9	15,853,112.3
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		123,006,650.4	120,734,217.4

4.2 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

		/мян.төг /	
Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2015 оны 12-р сарын 31	2016 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		92,463,736.6	100,049,744.0
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	20,615,262.4	24,905,689.6
Нийтлэг татварын бус орлого		20,279,207.6	24,864,789.9
Тусламжийн орлого		336,054.7	40,899.7
ТУСЛАМЖ, санхүүжилтийн орлого		71,848,474.2	75,144,054.4
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	92,402,074.8	106,401,137.6
УРСГАЛ ЗАРДАЛ		89,902,074.8	106,401,137.6
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		58,392,975.8	83,447,989.3
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		22,930,115.7	24,542,623.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		1,022,529.7	1,006,290.8
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		12,075,079.6	11,843,467.8
Хангамж, бараа материалын зардал		2,293,495.1	2,402,613.2
Нормативт зардал		147,311.1	8,778.8
Эд хогшил, урсгал засварын зардал		1,425,577.8	1,667,125.5
Томилолт, зочны зардал		5,315,871.7	3,863,597.1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		4,745,587.0	9,641,949.1
Бараа үйлчилгээний бусад зардал		8,437,408.1	28,471,543.8
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		31,509,099.0	22,953,148.2
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		2,500,000.0	0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УР ДҮН (Ш)=(1НП)		61,661.8	-6,351,393.6
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		233,318.12	535,452.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		433,133.6	340,672.2
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (Ү1)=(Ш)+0ҮМҮ)		-138,153.8	-6,156,613.9

4.3 Аудит хийгдсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	/мян.төг /	
			Нийт хөрөнгө /өмч	цэвэр
2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	113,211,686.4	0	113,211,686.4	
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	468,732.7	0	468,732.7	
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	113,680,419.1	0	113,680,419.1	
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-13,083.7	0	-13,083.7	
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	18,338.7	0	18,338.7	
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	7,160,526.3	0	7,160,526.3	
Тайлант үеийн үр дүн	-138,153.8	0	-138,153.8	
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	120,708,046.7	0	120,708,046.7	
2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	120,708,046.7	0	120,708,046.7	
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	117.7	0	117.7	
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	120,708,164.4	0	120,708,164.4	
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-408.5	0	-408.5	
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	2,032.6	0	2,032.63	
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	4,979,908.4	0	4,979,908.36	
Тайлант үеийн үр дүн	-6,156,613.9	0	-6,156,613.86	
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	119,533,083.0	0	119,533,083.0	

4.4 Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Тайлангийн үзүүлэлт	/мян.төг /	
	2015 оны 12-р сарын 31	2016 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДУН (I)	93,376,433.6	101,436,726.0
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	21,365,206.9	25,687,215.0
Нийтлэг татварын бус орлого	21,029,152.2	25,646,315.3
Тусламжийн орлого	336,054.7	40,899.7
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	72,011,226.7	75,749,511.0
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДУН	86,948,760.4	99,738,991.8
УРСГАЛ ЗАРДАЛ	86,948,760.4	99,738,991.8
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	54,592,895.9	76,133,126.4
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	22,214,031.7	25,271,974.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,021,704.1	1,171,382.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,881,434.4	13,688,260.5
Хангамж, бараа материалын зардал	2,340,848.7	3,266,839.7
Нормативт зардал	175,984.5	11,778.7
Эд хогшил, урсгал засварын зардал	1,600,524.9	841,433.9
Томилолт, зочны зардал	5,231,777.5	3,866,264.1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,706,969.8	5,797,778.8
Бараа үйлчилгээний бусад зардал	4,419,620.3	22,217,414.4
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32,355,864.5	23,605,865.4
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (Ш)=(I)-(П)	6,427,673.2	1,697,734.1
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДУН (V)	3,539,076.0	452,909.8
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,539,076.0	452,909.8
Дотоод эх үүсвэрээр	3,539,076.0	452,909.8
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-3,539,076.0	-452,909.8
САНХУУГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДУН	-340,784.5	206,504.0
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	340,784.5	-206,504.0
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (Vni)=(IID+(VI)+(Vn))	2,547,812.7	1,451,328.3
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6,313,243.6	8,861,056.3
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	8,861,056.3	10,312,384.6

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	74,338,435.6	70,592,759.8	3,745,675.8	95.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	73,737,235.6	69,991,559.8	3,745,675.8	94.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛ- ЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	71,494,780.3	67,929,894.0	3,564,886.3	95.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	22,885,166.1	23,030,630.5	(145,464.4)	100.6
210101	Үндсэн цалин	22,762,043.1	22,907,507.5	(145,464.4)	100.6
210102	Нэмэгдэл	123,123.0	123,123.0	-	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	898,675.0	903,136.9	(4,461.9)	100.5
210201	Тэтгэврийн даатгал	834,393.2	840,149.5	(5,756.3)	100.7
210202	Тэтгэмжийн даатгал	12,856.2	12,609.3	246.9	98.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	16,070.4	15,752.1	318.3	98.0
210204	Ажилгүйдлийн даатгал	3,214.2	3,147.9	66.3	97.9
210205	Эрүүл мэндийн даатгал	32,141.0	31,478.1	662.9	97.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,852,490.1	11,699,794.0	152,696.1	98.7
210301	Гэрэл, цахилгаан	978,243.5	750,197.9	228,045.6	76.7
210302	Түлш, халаалт	1,304,812.4	1,026,199.9	278,612.5	78.6
210303	Цэвэр, бохир ус	476,408.9	387,485.5	88,923.4	81.3
210304	Байрны түрээс	9,093,025.3	9,535,910.7	(442,885.4)	104.9
2104	Хангамж, бараа материалын зардал	1,820,748.6	2,498,139.9	(677,391.3)	137.2
210401	Бичиг хэрэг	225,733.6	286,539.1	(60,805.5)	126.9
210402	Тээвэр, шатахуун	746,165.6	946,691.3	(200,525.7)	126.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	679,934.2	878,188.9	(198,254.7)	129.2
210404	Ном, хэвлэл		17,585.0	(17,585.0)	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	168,915.2	369,135.5	(200,220.3)	218.5
2105	Нормативт зардал	22,688.2	11,778.7	10,909.5	51.9
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	22,688.2	11,778.7	10,909.5	51.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	749,560.8	838,405.4	(88,844.6)	111.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	25,503.8	252,308.1	(226,804.3)	989.3
210602	Тавилга	179,293.2	111,206.0	68,087.2	62.0
210604	Урсгал засвар	544,763.8	474,891.3	69,872.5	87.2
2107	Томилолт, зочны зардал	3,640,678.8	3,543,004.3	97,674.5	97.3
210701	Гадаад албан томилолт	2,931,531.8	2,791,905.4	139,626.4	95.2
210702	Дотоод албан томилолт	892.8	466.2	426.6	52.2
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	708,254.2	750,632.7	(42,378.5)	106.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,829,327.9	5,124,462.9	704,865.0	87.9

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	55,788.0	250,030.3	(194,242.3)	448.2
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,100.0	1,000.0	100.0	90.9
210803	Даатгалын үйлчилгээ	5,572,525.6	4 ,636,961.1	935,564.5	83.2
210804	Тээврийн хэрэгслийн татвар	100.0	100.0	-	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	20.0	12.9	7.1	64.5
210807	Газрын төлбөр	50,801.1	66,200.1	(15,399.0)	130.3
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	148,993.2	170,158.5	(21,165.3)	114.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,795,444.8	20,280,541.5	3,514,903.3	85.2
210901	Бараа үйлчилгээ-ний бусад зардал	23,142,112.7	19,537,707.9	3,604,404.8	84.4
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	653,332.1	742,833.6	(89,501.5)	113.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,242,455.3	2,061,665.8	180,789.5	91.9
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,786,449.8	1,671,905.9	114,543.9	93.6
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	1,786,449.8	1,671,905.9	114,543.9	93.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	456,005.5	389,759.9	66,245.6	85.5
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	235,349.1	226,781.2	8,567.9	96.4
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	220,656.4	162,978.7	57,677.7	73.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	601,200.0	601,200.0	-	100.0
2200	Дотоод эх үүсвэрээр	601,200.0	601,200.0		100.0
220001	Барилга байгууламж		100.0		100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	74,338,435.6	70,513,232.6	3,825,203.0	94.9
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	71,967,707.8	68,487,039.1	3,480,668.7	95.2
131001	Улсын төсвөөс санхүүжих	71,967,707.8	68,487,039.1	3,480,668.7	95.2
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,360,000.0	1,985,491.8	374,508.2	84.1
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,800,000.0	1,354,421.8	445,578.2	75.2
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	560,000.0	631,070.1	(71,070.1)	112.7
122	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	10,727.8	40,701.7	(29,973.9)	379.4
122002	Хандив тусламж /гадаад/	10,727.8	40,701.7	(29,973.9)	379.4
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		8,292.9		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		8,204.0		
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	638	640		
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	14	15		
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	410	410		
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	214	215		

